

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/026/НА-СТА-ОНТС

ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ХАЛАМЖИЙН САНГИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он

Аудитын гарын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитор: Ц.Г.Ариун-Уянга
Утас: 70272248 Цахим хаяг: ariun-uyangag@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	Error! Bookmark not defined.
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	Error! Bookmark not defined.
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	Error! Bookmark not defined.
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	Error! Bookmark not defined.
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 41100, Төв аймаг, Зуунмод сум Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn Цахны хаяг: www.audit.mn	ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Д.БАТЦЭЦЭГ ТАНАА
2026.02.16 № 01/88 танай _____-ны № _____-т	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.</p> <p>Дүгнэлтийн үндэслэл</p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>Асуудлыг онцолсон хэсэг</p> <p>Тайлант онд “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”-нд 29,959.2 мянган төгрөг батлагдсанаас 14,148.4 мянган төгрөгөөр худалдан авах ажиллагааг зарлаж “Монголын удирдлага шинэчлэлийн академи”-ийн газар шалгарч, 15,810.8 мянган төгрөгийн ажлыг дутуу гүйцэтгэж 47,2 хувьтай байна.</p> <p>Аудитын гол асуудал</p> <p>Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор нийгмийн халамжийн 69 төрлийн үйлчилгээг цахимд шилжүүлж, И-Халамжийн нэгдсэн системийн хөгжүүлэлт, сайжруулах ажлыг үе шаттайгаар гүйцэтгэсэн байна.</p> <p>Бусад асуудлын хэсэг</p> <p>Тус сан нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт, хэрэгжүүлэх 18 арга хэмжээтэй баталснаас, жилийн эцсийн байдлаар 92,5 хувьтай дүгнэгдсэн байна. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.</p>	
4116070108	

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн Орлого, үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1303	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО [2]+[3]	86,322,600.00	147,679,200.00
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтын орлого	86,322,600.00	147,679,200.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН [1]+[4]	86,322,600.00	147,679,200.00
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [19]-с [39]-р мөр	67,200,000.00	78,948,400.00
2.701E+09	Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	49,200,000.00	64,800,000.00
2.701E+09	ОНОТүшгэлсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	18,000,000.00	14,148,400.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН [10]+[15]+[18]+[40]	67,200,000.00	78,948,400.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН [9]-[50]	19,122,600.00	68,730,800.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1303	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО [2]+[3]	86,322,600.00	147,679,200.00
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтын орлого	86,322,600.00	147,679,200.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨВ [1]+[4]	86,322,600.00	147,679,200.00
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [18]+...+[38]	67,200,000.00	78,948,400.00
2701021300	Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	49,200,000.00	64,800,000.00
2701023000	ОНОТүшгэлсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	18,000,000.00	14,148,400.00
2603	Төсөвт төвлөрүүлэх [53]+[55]	19,122,600.00	68,730,800.00
260302	Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв	19,122,600.00	68,730,800.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН [12]+[17]+[39]+[49]+[52]+[61]-[62]+[63]-[64]	86,322,600.00	147,679,200.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

	Сангийн орлого	Төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Сангийн үйл ажиллагааны зардал [3]+[4]+[5]+[6]+[7]+[8]+[9]+[10]+[11]+[12]+[13]+[14]+[15]+[16]+[17]+[18]+[19]+[20]	147,679,200.00	78,948,400.00	68,730,800.00	46.54%
8	Олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээ	29,959,200.00	14,148,400.00	15,810,800.00	52.77%
16	Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	117,720,000.00	64,800,000.00	52,920,000.00	44.95%
22	УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ	147,679,200.00	147,679,200.00	-	0.00%
23	Тохируулгын дүн [1]+[11]-[2]-[15]	-	68,730,800.00	0	
24	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	-	-	0	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,455.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 26,455.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт 26,455.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс материаллаг зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

5.3 Зөвлөмж

1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь тайлант онд шилэн дансанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ"-ний тендерт шалгарсан худалдан авах ажиллагааны тайлан гүйцэтгэлийг мэдээлээгүй мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг мөнгөн гүйлгээний журналын орлого, зарлагын дүнтэй тулгахад орлого 12,306.6 мянган төгрөгөөр, зарлага 14,148.4 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.3.6-д “хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл байршуулаагүй гэж заасныг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид шилэн дансны мэдээллийг бүрэн гүйцэт мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn